



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№71 /285/

2022.04.12

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ БИЧГИЙН УРАЛДААНД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА



Батлан хамгаалахын сайдын тушаалаар Монголын ард түмний оюуны соёлын нандин өв болсон Монгол бичгээ хадгалан хамгаалж, сурч эзэмших, түгээн дэлгэрүүлэх идэвхийг өрнүүлэх, бүх нийтийг сургах, монгол бичгийн хэрэглэх орчныг бий болгох зорилгоор монгол бичгийн уралдааныг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний офицер ахлагч, ажилтан алба хаагч багш, судлаач, оюутан сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дунд ирэх сарын 5-6-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Уралдаан алдаагүй зөв бичих, таталган бичгийг алдаагүй зөв унших, цэвэр сайхан бичих, уран бичлэг, компьютерт эх бичвэрийг монгол бичгээр шивэх гэсэн 5 төрлөөр явагдана.

Оролцогч нь аль төрөлд орохоо өөрөө сонгох бөгөөд компьютерт эх бичвэрийг монгол бичгээр шивэх төрөлд оролцогч өөрийн зөөврийн компьютертой авчирна.

Төрөл тус бүр шилдэг 3 орлогчийг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагнал шагнаж "Соёмбо" сониноор сурталчлах юм.

“АХЛАГЧИЙН АЛБАНЫ ХӨГЖИЛ, ХЭТИЙН ТӨЛӨВИЙН ХҮРЭЭНД АХЛАГЧИД



Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний ахлагчийн албаны туршлага, сургамж үйл ажиллагаа, хэтийн төлөвийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхой чиглэлийн хүрээнд судалж тооцох зорилготой “Ахлагчийн албаны хөгжил, хэтийн төлөв” сэдэвт эрдэм шинжилгээ судалгааны ажлын хурал ҮБХИС-ийн “Сүбээдэй” танхимд зохион байгуулагдаж байна.

Хуралд ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал, хурандаа Б.Өлзийхуяг, ЗХЖШ-ын ахлагч тэргүүн ахлагч Д.Баасан болон Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт

хүчний нэгтгэл ангиудын тэргүүн ахлагч, ахлагчдын төлөөлөл оролцож байна. Хурлаар мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний ахлагчийн албаны эрх зүйн орчин, ахлагчийн албаны үнэт зүйлс, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчний ахлагчийн албаны хөгжил, ахлагч нарын ёс зүй, сахилга хариуцлагын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал, цэргийн алба хаагчийн эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн тогтвортой байдлын хангах арга зам, Зэвсэгт хүчний ахлагчийн сургалт бэлтгэл, заах арга зүйг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага, цахим сургалтын технологийн ахлагч

бэлтгэх сургалтад ашиглах боломж, энхийг сахиулах ажиллагаанд ахлагч нарын оролцоо, түүнд тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага, гадаад орнуудын Зэвсэгт хүчний ахлагчийн албаны онцлог /албаны тогтолцоо, цолны зэрэглэл, сургалт бэлтгэл, нийгмийн хамгаалал/ зэрэг сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлууд хийгджээ.

Дээрх сэдвийн хүрээнд Зэвсэгт хүчний ахлагчийн албаны бие бүрэлдэхүүн бэлтгэсэн илтгэлүүдийг өөрийн харьяа нэгтгэл, анги дээр хэлэлцээд шалгарсан бүтээлүүдээр өнөөдөр ийнхүү хэлэлцэн тэргүүний судалгааны ажлыг шалгаруулах аж.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,150.00	3,180.0
EUR 🇪🇺	3,505.0	3,550.0
CNY 🇨🇳	507.00	509.00
RUB 🇷🇺	36.00	37.00
JPY 🇯🇵	26.50	27.70
KRW 🇰🇷	2.62	2.68

ЗУРХАЙ



2022.04.12 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 11/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:
Эрхтэн хурц болно
Наран ургах, шингэх:
06.09-19.37
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй
Суудал: Огторгуй

Энэ өдөр гахай, туулай жилтнээ өлөөр үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, хийморийн дарцаг хатгахад сайн. Эрдэнийг гадагш өгөх, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохиистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.

АХМАД ДАЙЧДЫГ ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 065 дугаар анги 2022 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр тус ангид итгэл зүтгэл, бие сэтгэлээ зориулан ажиллаж байсан эрхэм хүндэт ахмад дайчдыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ ангийн ахмадын зөвлөлтэй хамтран амжилттай зохион байгууллаа.

Улс оронд үүссэн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ахмад дайчдаа 2 жилийн хугацаанд хүлээж аваагүй байсан тул энэ удаа зохион байгуулсан хүндэтгэлийн арга хэмжээнд анги байгууллагаас гавьяаныхаа амралтад гарсан, бэлтгэл чөлөөнд байгаа

170 гаруй ахмад дайчид идэвхтэй хамрагдаж нэг өдрийн ангийн байрлалд хуучин цагаа дурссан, анд нөхөхтэйгөө уулзсан нөхөрсөг уулзалт болов.

Ахмад дайчдыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ ангийн захирагчаар батлагдсан хөтөлбөрийн дагуу ахмад дайчдыг хүлээн авах угтах ажиллагаа, ангийн танилцуулга, урлагийн тоглолт, шагнал гардуулах ажиллагаа, Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ажиллагаа, дурсгалын зураг авалт, хүндэтгэлийн зоог, гарын бэлэг гардуулах гэсэн дараалалтайгаар зохион байгуулагдсан юм.

Ахмад З.АНХБАЯР

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,629 /69.9%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,933 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,034,179 31,8% 116,811 /3,6%/
НИЙТ БАТЛАГДСАН 8437 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 2	ЭДГЭРСЭН 8314

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 499,199,857

Эдгэрсэн

Нийт: 448,760,607

Нас барсан

Нийт: 6,203,372

ЭМД Эрдэмтэй мэргэжлийн шалтгааныг нь **ТӨР ХАРИУЦАН ТӨЛӨХ ИРГЭД**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2% -цар

- Тэтгэвэрээ өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн гэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өргөн тусуун иргэн
- Хүүхдээ 2 дугар бол 3 нас хүртэл нь өсгөн байхуйлж байгаа иргэд
- Хугацаат цэргийн албан хаагч
- Ил эрхлэж байгаа иргэн

сая 8,400T 0-----100,800T жилд

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1% -цар

- 0-18 насны хүүхэд

сая 4,200T 0-----50,400T жилд

Та өөрийн ЭМД-ын шалтгааныг мэдэхийн тулд байгаа газраа, хөдөлмөр шалтгааныг WWW.EMD.GOV.MN

Цахим шууданд

БЭЛЭН БАЙДЛЫГ ШАЛГАЖ ТОДОТГОЛ ХИЙВ



нэгдсэн төлөвлөгөөний дагуу сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүд гүйцэтгэх үүрэгт нь дадлагажуулах онол, дадлагын мэдлэгийг өглөө. Түүнчлэн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний томилгоот нэгжид томилогдсон бүрэлдэхүүнд орон нутгийн хамгаалалтын хуулийн тухай ойлголт өгч томилогдсон суман, тасагт үүргээ хэрхэн биелүүлэх талаар сургалт явуулж, цаашид сургалт, дадлагад хэрхэн оролцох талаар чиглэл өглөө. Мөн томилгоот бүрэлдэхүүнийг орон нутгийн хамгаалалтын хуулийн дагуу томилгоожуулсан эсэх, сум төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд цаашид анхаарах зүйлсийн талаар сумдын удирдлагад үүрэг чиглэл өгч ажиллаа.

Хошууч Г.БАТ-ӨЛЗИЙ

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб
Тус цэргийн штабаас хангайн сумдын Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний томилгоот нэгжийн

бүрэлдэхүүний бэлэн байдлыг шалгаж тодотгол хийх ажлыг 4 дүгээр сарын 4-өөс 8-ны өдрүүдэд зохион байгуулав.

Цэргийн штабын 2022 оны сургалт бэлтгэлийн

СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ СУРГАЛТ ЯВУУЛАВ



анги, аймгийн Тагнуулын газар мэдээлэл хийж хамтран ажиллалаа.

2021 онд Батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх ажилд идэвх санаачлаг гарган бусдыгаа манлайлан ажилласан Тариалан, Ховд, Зүүнхангай, Хяргас, Улаангом, Тэс сумдын ЗДТГ-ын дарга нарын шагнаж урамшууллаа. Түүнчлэн сумдын Зэвсэгт хүчний анги салбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнээр нөхөн хангах төлөвлөгөө, Орон нутгийн цэргийг зохион байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөөг 4 дүгээр сарын 9, 10-ны өдрүүдэд боловсруулж аймгийн Засаг даргаар батлууллаа.

Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын зүгээс Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар сумдын Засаг

даргын тамгын газрын дарга нартай 4 дүгээр сарын 11-ний өдөр сургалт зохион байгууллаа. Сургалтын үеэр аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар болон Хилийн цэргийн 0245 дугаар

"БОДЛЫН ХҮЧ, ҮГИЙН ХҮЧ, ӨӨРТӨӨ БОЛОН БУСДАД ИТГЭХ ИТГЭЛИЙН ХҮЧИЙГ МЭДРҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Ангийн соёл хүмүүжлийн албанаас мэдээллийн цагаар бие бүрэлдэхүүнд "Мөрөөдлийн хүч" сэдвээр Баян-Өлгий аймгийн эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч гишүүн Ж.Пүрэвсүрэн, "Өвөг урианхай" ТББ-ын гишүүн өв соёлоо түгээн чиглүүлэгч зөвлөгч багш Д.Адьяамөнх, ЮНЕСКО-ийн ёс зүйн багш, олон улсын оюуны дасгалжуулагч, эерэг сэтгэлгээний сургагч багш Ц.Ганцэцэг нар лекц уншиж эерэг сэтгэлгээний сургалтыг зохион байгууллаа.

Энэхүү сургалтаар "Бодлын хүч, үгийн хүч, өөртөө болон бусдад итгэх итгэлийн хүч, та бидний үйлдлийн хүч" хүний амьдралд, амжилтад ямар их чухал нөлөөтэй болохыг уран яруугаар өгүүлж, цэргийн алба хаагчдаар сэтгэл зүйн дасгал хийлгэн, үр дүнг нь үзүүлсэн юм. Мөн Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч хошууч О.Асылбек Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар яриа танилцуулга хийж, ангийн хуулийн офицер Х.Билэгжаргал Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль танилцууллаа.

Ахлах дэслэгч Б.ГЭРЭЛТ-ОД

"МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ" СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ ЯВУУЛЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

ЗХЖШ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 8/4872 дугаар албан тоотын дагуу нэгдсэн төлөвлөгөө боловсруулан, Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан Монгол цэргийн түүхэн замнал, Зэвсэгт хүчин, ангийн үйл ажиллагааг Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад сурталчлан таниулах, цэрэг эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх зорилгыг дэвшүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Зэвсэгт хүчний 032 дугаар анги БЗД-ийн 79 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчдад "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сургалт, сурталчилгааны ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу энэ сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээг ангийн захирагч хурандаа Ж.Мөнхбаяр нээж үг хэлж, сургуулийн захиргаанд дурсамж, дурсгалын зүйл гардууллаа. Мөн сурагчдад ирлагийн хэсэгчилсэн тоглолт, хугацаат цэргийн алба хаагчдын жагсаалын үзүүлэх тоглолт, энхийг сахиулах ажиллагааны оролцоо, ач холбогдлын тухай 30 минутын хугацаатай сургалтыг явуулан, энхийг

сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний зурагт альбом, анги байгууллагаа дурсгасан дурсгалын зүйлс, буудлагын зэвсгийн үзэсгэлэн дэлгэн, хийн буудлагын тэмцээнийг зохион байгуулсан юм. Түүнчлэн хийн буудлагын тэмцээнд 30 гаруй сурагчид оролцсоноос эрэгтэйчүүдийн төрөлд 11А ангийн сурагч Н.Баяр-Эрдэнэ 20 оноогоор, эмэгтэйчүүдийн төрөлд 11Б ангийн сурагч Г.Бадамсүрэн 19 оноогоор тус бүр тэргүүн байранд шалгарч, англи хэлний толь бичиг, ангийн дурсгалын зүйлээр шагнаж урамшууллаа.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

